

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 16 -ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.8 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.8.6 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК нь өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлагын хүрээнд компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Сэндли ББСБ ХК-ийн ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр тайлагнахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д даалгасугай.
3. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг зохих журмын дагуу эрх бүхий байгууллага болон олон нийтэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Мөнхцэцэг/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАЙБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 *26* оны *08* сарын *16* -ны өдөр

№ *03*

Улаанбаатар хот

*Монго угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын
болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК
(цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн Монго угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг I дүгээр Хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБЭХ



МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ДОТООД ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Мөнгө угаах болон терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх олон улсын стандарт шаардлага, Монгол Улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд Сэндли ББСБ ХК /цаашид “ББСБ” гэх/-ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх /цаашид “МУТС” гэх/-тэй тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах оновчтой, үр дүнтэй ажил зохион байгуулах, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавихад хөтөлбөрийн зорилго оршино.
- 1.2 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой нэмэлт өөрчлөлт орох хүртэл хугацаанд хөтөлбөрийг хэрэгжүүлэх бөгөөд тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлаар батлуулан мөрдөж ажиллана.
- 1.3 Хөтөлбөрийг ББСБ-ын төв болон салбар нэгж бүгд хэрэгжүүлнэ.
- 1.4 Зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 1.4.1 Харилцагч, бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх үйл ажиллагаанд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх аргачлалын дагуу үнэлгээ хийх;
 - 1.4.2 Өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
 - 1.4.3 Шинэ технологи болон өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийн эрсдэлийг бууруулах;
 - 1.4.4 Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа /цаашид “ХТМ” гэх/-г боловсронгуй болгох;
 - 1.4.5 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл, төрийн болон олон улсын холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх;
 - 1.4.6 Харилцагчийн данс гүйлгээнд тусгайлан хяналт тавих;
 - 1.4.7 Мөнгөн гуйвуулгыг гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
 - 1.4.8 Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба /цаашид “СМА” гэх/ болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх, хадгалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

- 1.4.9 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн Гүйцэтгэх захирлын баталсан дотоод сургалтын хөтөлбөрийн дагуу үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх.

Хоёр. Зорилтын хүрээнд хийгдэх ажил

Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд дараах үйл ажиллагааг зохион байгуулна. Үүнд:

2.1 Харилцагч, бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх үйл ажиллагаанд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх аргачлалын дагуу үнэлгээ хийх:

- 2.1.1 ББСБ-д бүртгэлтэй нийт харилцагчийн эрсдэлийн үнэлгээг аргачлалын дагуу хийх;
- 2.1.2 Харилцагч шинээр бүртгэхийн өмнө эрсдэлийн үнэлгээг аргачлалын дагуу хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн бизнесийн харилцаа тогтоох, харилцааг цуцлах;
- 2.1.3 Бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх сувгийн эрсдэлийн үнэлгээг аргачлалын дагуу хийх.

2.2 Өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх:

- 2.2.1 Дараах харилцагчийг өндөр эрсдэлтэй харилцагчийн нэгэн адил авч үзэж таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 2.2.1.1 Улс төрд нөлөө бүхий этгээд, түүний хамааралтай болон нэгдмэл сонирхолтой этгээдийг;
- 2.2.1.2 МУТС-тэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТС-тэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын харилцагчийг;
- 2.2.1.3 Эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн харилцагчийг;
- 2.2.1.4 МУТС-тэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа харилцагчийг.
- 2.2.2 Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг авна. Үүнд:
- 2.2.2.1 Тухайн харилцагчийн эрхэлж буй ажил, бизнес, хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зориулалт, утга зэрэгтэй холбоотой нэмэлт мэдээллийг гаргуулж авах, боломжийн хэмжээнд эдгээр мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах;
- 2.2.2.2 Тухайн харилцагчтай бизнесийн харилцааг цаашид үргэлжлүүлэх эсэх талаар Гүйцэтгэх удирдлагын зөвшөөрлийг авна. МУТС эрсдэл бүхий харилцагч болон үнэн зөв мэдээллийг өгөхөөс зайлсхийсэн харилцагчтай бизнесийн харилцаа үүсгэхээс татгалзах;
- 2.2.2.3 Харилцагчийн данс, гүйлгээнд тавих хяналт давтамжийг нэмэгдүүлэх, хяналтын цар хүрээг өргөжүүлэн харилцаж байгаа бусад этгээдийг

хяналтад хамруулах, харилцагчийг таньж мэдэх зорилгоор харилцагчаас гаргуулан авах мэдээллийг эргэж хянах;

2.2.2.4 Бүтээгдэхүүн, үйлчилгээ авах бүрт нь холбогдох нэмэлт мэдээллийг авах, өмнө нь өгсөн мэдээлэлд гарсан өөрчлөлтийг тусгах замаар байнгын үргэлжлэх хэлбэрээр хэрэгжүүлэх.

2.3 Шинэ технологи болон өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийн эрсдэлийг бууруулах:

2.3.1 Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр, хэлбэрийг нэвтрүүлэхийн өмнө тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийн МУТС зорилгоор ашиглагдах эрсдэлийг үнэлэх;

2.3.2 Өмнө байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэл шинэ технологийг нэвтрүүлснээр хэрхэн өөрчлөгдөхийг үнэлэх;

2.3.3 Шинэ технологи нэвтрүүлснээс үүдэх МУТС эрсдэлийг бууруулах, үр нөлөөг нь багасгах талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2.4 Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг боловсронгуй болгох:

2.4.1 ХТМ үйл ажиллагаатай холбоотой журам, зааврыг боловсронгуй болгох;

2.4.2 Харилцагч шинээр бүртгэхийн өмнө ХТМ арга хэмжээг хэрэгжүүлэх, тухайн харилцагчид эрсдэлийн үнэлгээг хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн бизнесийн харилцаа тогтоох, харилцааг цуцлах;

2.4.3 Харилцагчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг магадлан шалгах, тодорхойлох;

2.4.4 Харилцагчийн мэдээллийн шинэчлэлт, хувийн хэргийн бүрдэлийг программын түвшинд хянах;

2.4.5 ХТМ үйл ажиллагааны хүрээнд харилцагчийн бүрдүүлсэн баримт бичиг, хувийн хэргийн бүрдэл мэдээллийг бүтээгдэхүүн, үйлчилгээ авах бүрд шинэчлэн, хадгалалтыг магадлан шалгаж ажиллах.

2.5 Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх:

2.5.1 ББСБ нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд харилцагч болон эцсийн өмчлөгчийг тодорхойлох, харилцагчийг үнэлэх, программ хангамж, мэдээллийн сан авах зэрэг үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

2.5.1.1 Гуравдагч этгээдийн ББСБ-тай байгуулсан гэрээний хүрээнд гуравдагч этгээдийн цуглуулсан баримт бичиг, мэдээ мэдээллийг авах эрхтэй байх;

2.5.1.2 Тухайн гуравдагч этгээдийн үйл ажиллагаа нь МУТС-тэй тэмцэх хууль тогтоомжийн шаардлага, мөн бусад улс оронд үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд тухайн улсын зохицуулагч байгууллагын шаардлагад нийцэж байх;

2.5.1.3 Гуравдагч этгээдийн үйл ажиллагааны тайлан, гэрээний хэрэгжилтийн хүрээнд хийгдсэн ажлын тайланг хөтөлбөрийн 5 дугаар зүйлд заасны дагуу тайлагнана.

2.6 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл, төрийн болон олон улсын холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх:

- 2.6.1 ББСБ нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөл болон эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээний жагсаалт /цаашид “Хориг жагсаалт” гэх/-д орсон хувь хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийн талаарх мэдээллийг бүртгэлийн программд тухай бүр бүртгэн оруулах;
- 2.6.2 ББСБ-д шинээр харилцагч бүртгэх, данс нээх, данстай болон дансгүй харилцагч гүйлгээ хийхэд “Хориг жагсаалт”-аас тулган шалгаж, жагсаалтад байгаа тохиолдолд үйлчилгээ үзүүлэхгүй байх;
- 2.6.3 Хориг жагсаалтад бүртгэлтэй хувь хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийн нэр илэрсэн, мэдсэн даруйд урьдчилан мэдэгдэлгүйгээр холбогдох данс, итгэлцэлийн хөрөнгийн хөдөлгөөнийг шууд зогсоох;
- 2.6.4 Хориг жагсаалтад орсон этгээдийн гүйлгээ хийх оролдлогын талаар нэгжийн ажилтан Комплайнсын нэгжид, Комплайнсын нэгж нь СМА-д даруй мэдээлэх;
- 2.6.5 Бүртгэлийн ажилтан харилцагчийг Хориг жагсаалтаас заавал шалгах, жагсаалтад байгаа тохиолдолд программын түвшинд үйлчилгээ үзүүлэхгүй байх, мэдээлэх зэрэг үүргийг хэрэгжүүлэх шат дараалсан дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх;
- 2.6.6 Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үйл олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологи болон үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зорилгоор хоёрдмол зориулалттай бараа бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, олж авах, тээвэрлэх, экспортлох, шилжүүлэх, хуримтлуулах худалдах, худалдан авах, ашиглахад бүрэн, эсхүл хэсэгчилсэн санхүүгийн дэмжлэг, үйлчилгээг үзүүлж буй эсэхэд хяналт тавьж ажиллах;
- 2.6.7 МУТС-тэй тэмцэх хуулийн дагуу ББСБ нь жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгийг царцаасантай холбоотой авсан арга хэмжээний тайланг СМА-д мэдээлэх;
- 2.6.8 Комплайнсын нэгжээс МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т заасны дагуу тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын тухай мэдээллийг эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад гаргаж өгөх ажлыг зохион байгуулна.

2.7 Тусгайлан хяналт тавих үйл ажиллагаа:

- 2.7.1 Комплайнсын ажилтан болон нэгжээс МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасны дагуу дараах гүйлгээнд тусгайлан хяналтыг тавьж ажиллана. Үүнд:
- 2.7.1.1 Огцом өөрчлөгдсөн их дүнтэй;
 - 2.7.1.2 Эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй;
 - 2.7.1.3 Улс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийсэн;
 - 2.7.1.4 Олон Улсын Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага/FATF/-аас МУТС-тэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсаар дамжиж буй аливаа гүйлгээ.
- 2.7.2 ББСБ нь харилцагчийн данс, гүйлгээнд тусгайлан хяналт тавих үйл ажиллагааг автоматжуулж, программ хангамжийн хөгжүүлэлт, сайжруулалтыг тогтмол хийнэ.
- 2.7.3 ББСБ нь тусгайлан хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлсэн дүн шинжилгээний үр дүнг Тусгай хяналтын бүртгэл хийж, тэмдэглэж хадгална.
- 2.8 Мөнгөн гуйвуулгыг гүйцэтгэх үйл ажиллагаа:**
- 2.8.1 ББСБ нь мөнгөн гуйвуулгын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ харгалзах улс орны шаардлагаас хамаарсан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг энэ хөтөлбөрийн 2.5, 2.6 заалтуудыг харгалзан хэрэгжүүлнэ. Программын түвшинд дүрэм тохируулах, сайжруулах, шинэчлэх, хяналт тавих үйл ажиллагааг тогтмол боловсронгуй болгохыг эрмэлзэх бөгөөд 1 жил тутам хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 2.8.2 Программ хангамжийг тасралтгүй сайжруулах, бүрэн автоматжуулж, гүйлгээний хяналт, тайлан мэдээг боловсронгуй болгоход анхаарч ажиллана.
- 2.8.3 Мөнгөн гуйвуулга шилжүүлэгч болон хүлээн авагчийн хоорондын хамаарал, шилжүүлгийн зорилго, үнийн дүн зэрэгт хяналт тавьж ажиллах бөгөөд бусад зохицуулалтыг Мөнгөн гуйвуулгын үйл ажиллагааны журмын дагуу удирдана.
- 2.9 Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх, хадгалах:**
- 2.9.1 Сэжигтэй гүйлгээг таньж мэдэх, олж илрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор олон улсын жишээ /кейс/-д үндэслэсэн сэжигтэй гүйлгээний жишээ, гарын авлагыг шинэчлэх, сайжруулах;
- 2.9.2 Сэжигтэй гүйлгээ илрүүлэх программ хангамжийг автоматжуулах;
- 2.9.3 Сэжиг бүхий гэж үзсэн гүйлгээ, гүйлгээтэй холбоотой нэмэлт мэдээллийг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журмын дагуу Комплайнсын ажилтан болон нэгжид мэдээлэх;

- 2.9.4 Нэгжээс ирүүлсэн сэжигтэй гүйлгээнд Комплайнсын нэгжийн ажилтан дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд СМА-д хүргүүлэх;
- 2.9.5 Комплайнсын ажилтан болон нэгж нь гүйлгээнд дүн шинжилгээ хийж, сэжигтэй гэж үзсэн тохиолдолд МУТС-тэй тэмцэх хуулийн дагуу СМА-д хүргүүлэх;
- 2.9.6 Гүйлгээний хяналт, сэжигтэй гүйлгээний мэдээллийг МУТС-тэй тэмцэх тухай хуулийн дагуу таваас доошгүй жилийн хугацаанд хадгалах;
- 2.9.7 Сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний тайланг бэлтгэх, мэдээлэхдээ нууцлалын зэргийг хангаж СМА-д хүргүүлэх;
- 2.9.8 СМА-аас ирүүлсэн харилцагч болон гүйлгээний мэдээллийг Комплайнсын ажилтан болон нэгжээс МУТС тэмцэх хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, 7.5-т заасны дагуу нууц үгээр хамгаалж хүргүүлнэ.
- 2.9.9 Эрх бүхий байгууллагад мэдээлсэн харилцагч болон гүйлгээний мэдээллийн үнэн зөв байдалд хяналт, тулгалт хийж ажиллах.

2.10 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх журам, түүний эрх, үүрэг:

- 2.10.1 МУТС-тэй тэмцэх хууль болон хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий ажилтан нь удирдах түвшиний ажилтан байна.
- 2.10.2 Дараах шаардлагыг хангасан ажилтныг Комплайнсын чиг үүрэг, үйл ажиллагааг хариуцуулна. Үүнд:
 - 2.10.2.1 Комплайнсын чиг үүргийг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвар, бэлтгэлтэй байх;
 - 2.10.2.2 Шудрага, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
 - 2.10.2.3 Гэмт хэрэг, зөрчил ялангуяа залилан, луйвар, мөнгө угаах зэрэг эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгэгдэж байгаагүй.
- 2.10.3 Хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нь ББСБ-ын бүх төвийн нэгжүүд болон салбар нэгжээс харилцагч, данс, гүйлгээтэй холбогдох бүх баримт бичиг, мэдээллийг гаргуулан авах, нэвтрэх, эрхтэй байна.
- 2.10.4 ББСБ нь МУТС-тэй тэмцэх үүргийн хэрэгжилтийг шалгадаг, МУТС-тэй тэмцэх дотоод бодлого, журам, хяналтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнтэй байдалд хяналт тавих чиг үүрэг бүхий удирдлагаас хараат бус, ажил үүргээ гүйцэтгэх хангалттай нөөц бололцоогоор хангагдсан Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан нэгж байна.

2.11 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөр:

- 2.11.1 Комплайнсын ажилтан болон нэгж нь МУТС-тэй тэмцэх чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулан ББСБ-ын ажилтнуудад дараах сургалтыг жил бүр зохион байгуулна. Үүнд:

- 2.11.1.1 ББСБ-ын МУТС-тэй тэмцэх үйл ажиллагааны талаарх ерөнхий ойлголт, хууль эрх зүйн орчин, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар;
- 2.11.1.2 Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, хувийн хэргийн бүрдлийг хангах үйл ажиллагаа;
- 2.11.1.3 Улс төрд нөлөө бүхий этгээд, Эцсийн өмчлөгчийг тодорхойлох;
- 2.11.1.4 Олон улсын хориг арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 2.11.1.5 Данс гүйлгээнд хяналт тавих;
- 2.11.1.6 Өндөр эрсдэлтэй харилцагч болон тусгай хяналтыг хэрэгжүүлэх асуудал;
- 2.11.1.7 Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаа;
- 2.11.1.8 Бусад.
- 2.11.2 Ажилтны мэдлэгийг баталгаажуулах зорилгоор шалгалт, сорилыг жилд 1 удаа авч ажиллана.
- 2.11.3 Комплайнсын ажилтан болон нэгж нь МУТС-тэй тэмцэх чиглэлээр зурагт хуудас, зөвлөмж, санамж бичгийг нийт нэгжүүдэд хүргүүлнэ.
- 2.11.4 Төвийн болон салбар нэгжийн ажилтныг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх сургалт:
 - Комплайнсын нэгжийн ажилтан болон нэгжээс тусгайлсан сургалт зохион байгуулах;
 - Банк, санхүүгийн академи болон бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад хамруулах;
- 2.11.5 Комплайнсын нэгжийн ажилтныг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх сургалт:
 - Монголбанк СМА, ТЕГ, АТГ зэрэг эрх бүхий байгууллагаас зохион байгуулах сургалтад хамруулах;
 - Банк, санхүүгийн академи болон бусад гадаад, дотоодын байгууллагаас зохион байгуулах сургалтад хамруулах;
 - Олон улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх байгууллага, бусад сургалтын байгууллагаас зохион байгуулах сургалтад хамруулах.

2.12 Хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасан бусад нөхцөл, шаардлага:

- 2.12.1 Хөтөлбөр нь ББСБ-ын бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалт, эрсдэлийн түвшинд нийцсэн байх бөгөөд хөтөлбөрийг ББСБ-ын удирдлага батална. Хөтөлбөрийг ББСБ-ын төвийн болон салбар нэгж нэгэн адил хэрэгжүүлнэ.
- 2.12.2 ББСБ МУТС-тэй тэмцэх дотоод бодлого, журам, хяналтын тогтолцоог сайжруулж ажиллана.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн

- 3.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:
- 3.1.1 ББСБ-ын ХТМ үйл ажиллагааг сайжруулж, ББСБ-д бүртгэлтэй идэвхтэй харилцагчийн мэдээллийг бүтээгдэхүүн, үйлчилгээ авах бүрд бүрэн шинэчилсэн байна.
 - 3.1.2 ББСБ-ын хэмжээнд хийгдэж буй нийт гүйлгээг Сэжигтэй гүйлгээний хяналтын программын дүрмээр хянаж, баригдсан нийт гүйлгээг бүрэн хянаж ажилласан байна.
 - 3.1.3 ББСБ харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэлийг тогтмол үнэлж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг авснаар МУТС үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлж ажилласан байна.
 - 3.1.4 ББСБ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийг жил бүр үнэлж, эрсдэлийг бууруулж ажилласан байна.
 - 3.1.5 Хориг жагсаалтыг тухай бүр шинэчилж, хориг жагсаалтад багтсан этгээд ББСБ-аас аливаа үйлчилгээ авахаас урьдчилан сэргийлж таслан зогсоосон байна.
 - 3.1.6 ББСБ-ын ажилтнуудад МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаа, харилцагчийг таньж мэдэх, гүйлгээнд хяналт тавих зэрэг чиглэлээр шаардлагатай мэдлэгийг сургалтаар дамжуулан олгосон байна.
 - 3.1.7 ББСБ-ын МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой журмуудад тухай бүр шинэчлэлт сайжруулалтыг хийж, тогтолцоо тасралтгүй сайжирсан байна.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт

- 4.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал удирдлагаар хангаж, Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан нэгж хяналт тавьж ажиллана.
- 4.2 Хөтөлбөрийн хэрэгжилтэд дараах төвийн нэгжүүд дор дурдсан үүрэгтэйгээр оролцоно. Үүнд:
 - 4.2.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг ББСБ-ын хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг Комплайнсын ажилтан болон нэгж зохион байгуулж тайлагнах;
 - 4.2.2 Харилцагч таньж мэдэх, тусгайлан хяналт, харилцагчийн хувийн хэргийн бүрдүүлэлт, хадгалалт, мэдээллийн нууцыг хангаж ажиллахад хяналт тавих ажлыг Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан нэгж;
 - 4.2.3 Программ хангамжийн хөгжүүлэлт, сайжруулалтыг Мэдээллийн технологи хариуцсан нэгж;
 - 4.2.4 Ажилтанд мэдээлэл хүргэх, сургалт зохион байгуулах ажлыг Хүний нөөц хариуцсан нэгж;
 - 4.2.5 Харилцагчийн мэдээлэл шинэчлэл, хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт тавих ажлыг Салбарын удирдлага хариуцсан нэгж;

- 4.2.6 МУТС-тэй тэмцэх хууль тогтоомж болон бусад эрх бүхий байгууллагын эрх зүйн баримт бичигт өөрчлөлт орсон тухай бүр удирдлагыг мэдээллээр хангах, нийт ажилтанд танилцуулахыг Комплайнсын ажилтан болон нэгж;

Тав. Тайлагнал

- 5.1 Комплайнсын ажилтан болон нэгж энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх дараах тайланг Төлөөлөн удирдах зөвлөлд хагас жил бүр хүргүүлж, танилцуулна. Үүнд:
- 5.1.1 Сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл болон үр дагаврын тухай мэдээлэл;
- 5.1.2 МУТС-тэй тэмцэх дотоод бодлого, журам, хяналтын тогтолцоог сайжруулахтай холбогдуулан авсан арга хэмжээ, үр дүн;
- 5.1.3 МУТС үйл ажиллагаанд өртөх эрсдэлийн үнэлгээ, эрсдэл бууруулах арга хэмжээ, үнэлгээний үр дүн;
- 5.1.4 Эрх бүхий хяналт шалгалтын байгууллагаас болон СМА-аас хийсэн хяналт шалгалтын үр дүн;
- 5.1.5 МУТС-тэй тэмцэх чиглэлээр хийсэн хяналт шалгалтаар ББСБ-д өгсөн үүрэг даалгавар, засаж залруулах шаардлагатай арга хэмжээний талаарх мэдээлэл.
- 5.2 ББСБ-ын МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаа, энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтэд Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан нэгж шалгалт хийж, хяналт тавьж ажиллана.

о оОо о